
Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II үе

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК

2012 оны 9 дугаар сар



Улаанбаатар Цэвэр Агаар сан – II үе
Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагаанд холбогдох хууль,
дүрмийг дагаж мөрдөх үйл ажиллагааны гарын авлага
(Ажлын даалгавар 3.4.16)

Огноо: 2012 оны 9 дугаар сар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЕСБХБ

БОАЖЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл:

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
1	07/27/2012	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пиет де Вилдт Д.Эрдэнэ		
2	08/20/2012	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пиет де Вилдт Д.Эрдэнэ		
3	09/15/2012	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пиет де Вилдт Д.Эрдэнэ		

УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААР САНААЧЛАГА II

Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд хоол хүнс бэлтгэх, гэр сууцаа халаахдаа хэрэглэж байгаа зуух нь бүтээмж бага, мөн түлшний зориулалтаар ашиглаж буй нүүрсний чанар муу тул өвлийн улиралд агаарын бохирдлыг үүсгэдэг гол хүчин зүйл болж байна. Улаанбаатар хотын агаарын чанарын түвшин жилээс жилд буурч, хотын хүн амын эрүүл мэнд, улс орны эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх хандлага нэгэнт бий болжээ. Гэр хорооллын айлуудын ашиглаж буй зуухны загварыг сайжруулж, түүхий нүүрсийг шууд хэрэглэж байгааг шигшиж цэвэршүүлсэн, утаа ялгаруулалт багатай, үр ашигтай түлшээр солих нь Улаанбаатар хотыг хамарсан агаарын бохирдлын асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх арга зам, гарц болоод байна. 2008 оноос эхлэн Улаанбаатар хотын удирдлагууд түүхий нүүрс түлшинд хэрэглэхийг хориглосон ч цэвэр түлшний хангамж хязгаарлагдмал, өртөг өндөр, мөн тухайн харилцааг зохицуулах хууль, эрхзүйн орчин тодорхой бус байсны улмаас тус хориг нь төдийлэн биелэлээ олоогүй юм. Олон улсын санхүүгийн байгууллагууд (цаашид “ОУСБ-ууд” гэх), хөгжлийн агентлагууд, хандивлагч байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын (цаашид “Засгийн газар” гэх) хүсэлтээр агаарын бохирдолд нөлөөлж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банк нь зуухыг шинэчлэн солих хөтөлбөрийг боловсруулахаар тохиролцсон бөгөөд Засгийн газрын зүгээс Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкинд (цаашид “ЕСБХБ” эсвэл “Банк” гэх) түлшийг шинэчлэн солих ажлын тодорхой хэсэгт тусламж үзүүлэх хүсэлт тавьсан. ЕСБХБ нь 2008 оны 09 дүгээр сараас түүхий нүүрсний хэрэглээг цэвэр, хор багатай түлшээр солих төлөвлөгөөг боловсруулахаар Засгийн газартай хамтран ажиллаж эхэлсэн юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд 2009 оны 06 дугаар сард Засгийн газарт өргөн мэдүүлсэн Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөнд (“Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө” гэх) тусгагдсан юм. Энэхүү төслийн 1 дүгээр үе шатны үр дүнгийн нэг хэсэг нь Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө нь түлшийг шинэчлэн, солихтой холбоотой, өөр хоорондоо харилцан уялдаа бүхий олон асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн цогц арга, аргачлалаас бүрдэнэ. 2010 оны 06 дугаар сард Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг Засгийн газар, Агаарын тухай багц хуулийг Монгол Улсын Парламентаар баталсны дараа Банк төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэхээр зорьж байна. Энэхүү бичиг баримт нь Засгийн газарт Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх Зөвлөх мэргэжилтнүүдэд зориулсан ажлын удирдамж болно.

АГУУЛГА

1.ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА-Танилцуулга.....	7
2. ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОН ҮҮССЭН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ.....	8
2.1 Эрүүгийн гэмт хэргийн шинж бүхий асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам.....	8
2.1.1 Эрүүгийн хэргийн тухай ойлголт.....	8
2.1.2 Эрүүгийн хэргийг шийдвэрлүүлэх	9
2.1.3 Хэргийг хянан шийдвэрлэх хугацаа, үе шат.....	9
2.2. Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэхэд баримтлах журам.	11
2.2.1 Иргэний хэрэг маргааны тухай ойлголт	11
2.2.2 Иргэний нэхэмжлэл гаргах.....	11
2.2.3 Шүүх хэргийг хянан шийдвэрлэх	13
2.2.4 Шүүхийн шийдвэрийг биелүүлэх.....	14
2.3 Захиргааны хэрэг маргаан шийдвэрлэх.....	14
2.3.1 Захиргааны хэрэг маргааны тухай ойлголт.....	14
2.3.2 Гомдол, нэхэмжлэл гаргах	15
2.3.3 Шүүх хэргийг шийдвэрлэх.....	16
2.4 Бусад эрх бүхий байгууллага байгууллага албан тушаалтан	16
2.4.1 Захиргааны зөрчлийг шийдвэрлэх	16
Хавсралт -1.....	18
Товч хураангуй	18
Хавсралт-2	20
ЦЭВЭР АГААР САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ.....	20

1.ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРМИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА-Танилцуулга

Улаанбаатар хотын цэвэр агаар санаачлага II төслийн ажлын удирдамжийн¹ дэх хэсэгт заасан “.....” гэсэн даалгавын хүрээнд “ЦАС”-гийн ажилтан албан тушаалтнуудад зориулан тус сангаас аливаа зөрчил, маргаан гарсан тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх товч судалгаа хийн холбогдох хууль тогтоомжуудыг эмхэтгэн гаргасан болно. Үүсгэн байгуулагдсан хууль зүйн үндэслэл, удирдлага, бүтэц зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, түүнд тавигдах хяналт, бусад байгууллагатай харилцах харилцаа зэрэг нөхцөл байдлуудыг судлан тодорхойлоход энэхүү бүлгийн гол зорилго оршиж байгаа болно.

Энэхүү гарын авлага нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдсэн бөгөөд эдгээр хууль тогтоомжоос “Цэвэр агаар сан”-гийн үйл ажиллагааг зохицуулж буй тодорхой зүйл заалтуудыг түүвэрлэн, нэгтгэж ойлгомжтой байдлаар томъёолсон юм.

“ЦАС”-гийн үйл ажиллагааг зохицуулж буй хүчин төгөлдөр хууль тогтоомжууд болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд хууль болон гэрээ, холбогдох дүрэм, заавар хэрэгжүүлээгүй эсхүл зөрчсөн үйлдэл эс үйлдлийг хууль тогтоомжийн дагуу албадлагын арга хэмжээ хэрхэн авч хэрэгжүүлэх, ийнхүү албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх хууль зүйн үндэслэл байгаа эсэх талаарх нөхцөл байдлыг судалж гарын авлагад багтаасан болно.

Иймээс энэхүү гарын авлагаас албадлагын арга хэмжээг хэн хэрэгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэрийн талаар тодорхой хэмжээгээр ойлголт өгсөн ач холбогдолтой судалгаа болох юм.

¹ 201.....оны сард.... баталсан

2. ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОН ҮҮССЭН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ.

2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 25 дугаар зүйлд Цэвэр агаар сангийн талаарх зохицуулалт орсон бөгөөд энэхүү Агаарын тухай хуулийн заалтыг үндэслэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль²д 2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.29-д “Цэвэр агаар сан”-г тусгай сангийн төрөлд оруулан хуульчилсан юм.

Улмаар 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 273 тоот Засгийн газрын тогтоолоор “ЦАС-гийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ыг баталсан байна.

“Цэвэр агаар сан” нь агаарыг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагаанд зориулан уг сангаас санхүүжүүлсэн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулах зорилготойгоор³ үүсгэн байгуулагдах эрх зүйн үндэслэл бий болсон байна.

Үүнээс үзэхэд тус сан нь ямар нэгэн этгээдэд албадлагын арга хэмжээ авах, хариуцлага тооцох эрх бүхий субъект биш байх бөгөөд харин эрх бүхий этгээдэд хандан хуулийн дагуу аливаа зөрчил, маргааныг шийдвэрлүүлэх боломжтой юм.

Ийнхүү шийдвэрлүүлэх хууль зүйн боломжуудыг судалж энэхүү гарын авлагад тусгахыг хичээсэн болно.

2.1 Эрүүгийн гэмт хэргийн шинж бүхий асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам.

2.1.1 Эрүүгийн хэргийн тухай ойлголт

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ⁴ гэж заасан байдаг.

Гэмт хэргийг тодорхойлох шинж нь:

² Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2006 оны 6 сарын 29 өдөр батлагдсан. /6 бүлэг, 33 зүйлтэй./

³ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын сан”-гийн дүрэм

⁴ Эрүүгийн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1

- Тухайн зөрчил гаргасан этгээдийн үйлдэл, эс үйлдэл Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байгаа эсэхийг тодорхойлох
- Нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл эс үйлдэл байх эсэхийг тодорхойлох

... шаардлагатай бөгөөд дээрх шинж байвал гэмт хэрэг гэж үзнэ.

2.1.2 Эрүүгийн хэргийг шийдвэрлүүлэх

Хэрэв “Цэвэр агаарын сан”-гийн хувьд бусдын хууль бус үйлдлийн улмаас хохирол учирсан, ийнхүү хохирол учруулсан этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй тохиолдолд гэмт хэргийн талаарх мэдээллийг бичгээр өгөх бөгөөд түүнд холбогдох баримт, материалыг хавсаргаж болно.

Мэдээллийг Авилгатай тэмцэх газар, Тагнуулын төв газар, Цагдаагийн байгууллага, Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба зэрэг хэрэг бүртгэл мөрдөн байцаалт явуулдаг эрх бүхий байгууллагуудад бичгээр гэмт хэргийн талаар гомдол гарган шийдвэрлүүлнэ.

Ийнхүү гомдол гаргахдаа дээрх байгууллагуудын харьяаллын дагуу гаргах шаардлагатай. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26, 27 дугаар зүйлүүдэд хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулах байгууллагуудын хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах гэмт хэргүүдийг тодорхойлсон байдаг. Энэхүү хуульд заасны дагуу харьяалах байгууллагад өргөдөл гомдол гарган шийдвэрлүүлнэ.

Хэрэв гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.⁵

Иргэний нэхэмжлэлийг эрүүгийн хэргийг үүсгэснээс эхлэн шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх шатанд гаргаж болно⁶.

2.1.3 Хэргийг хянан шийдвэрлэх хугацаа, үе шат

2.1.3.1 Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан хянаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ⁷.

Нэмэлт тайлбар, баримт бичиг, бусад материал гаргуулж авах, хэргийн газарт үзлэг хийх шаардлагатай бол энэхүү хугацааг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга 14 хүртэл хоногоор сунгаж болдог⁸.

⁵ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115 дугаар зүйлийн 115.1

⁶ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 116 дугаар зүйлийн 116.1

⁷ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1

⁸ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 171 дүгээр зүйлийн 171.2

Эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 21 хоног байдаг.

Хэрэг бүртгэлтийн нэмэлт ажиллагаа хийх зайлшгүй шаардлага гарвал прокурор хэргийн хугацааг тухай бүрт нь 15 хүртэл хоногоор, шүүхээс нэмэлт хэрэг бүртгэлт хийлгэхээр прокурорт буцаасан, түүнчлэн түдгэлзүүлсэн буюу хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээсэн бол хэрэг бүртгэлт явуулах хугацааг прокурор 15 хоногоор сунгана.

Харин мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 2 сар байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 182 дугаар зүйлийн 182.4-д заасны дагуу дээрх хугацааг сунгадаг.

2.1.3.2 Прокурорын хяналт

Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа дууссаны дараа хэргийг прокурорт шилжүүлдэг. Прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэхүү хугацааг 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно⁹.

Прокурор хэргийг хянаад доорх шийдвэрүүдийн аль нэгийг гаргадаг.

- хөнгөн гэмт хэрэгт яллагдагчаар татсан тогтоолыг баталж, хэргийг шүүхэд шилжүүлэх;
- хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлэх;
- нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах;
- хуульд заасан үндэслэл тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгох;
- хэргийг түдгэлзүүлэх;
- хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх.

Хэрэв прокурор яллах дүгнэлт үйлдэх бол 10 хоногийн дотор үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлнэ.

2.1.2.2 Шүүхийн ажиллагаа

Шүүхэд ирсэн хэргийн талаар шүүгч дараахшийдвэрийн аль нэгийг гаргана:

- яллагдагчийг шүүхэд шилжүүлэх;
- хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр хэргийг буцаах;
- хэргийг түдгэлзүүлэх;
- хэргийг харьяалах шүүхэд нь шилжүүлэх.¹⁰

Шүүгч захирамжаа хэрэг шүүхэд ирснээс хойш 15 хоногийн дотор гаргана. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс эхлэн 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж эхэлнэ.

⁹ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 215 дүгээр зүйлийн 215.1

¹⁰ Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 225.1

2.2. Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэхэд баримтлах журам.

2.2.1 Иргэний хэрэг маргааны тухай ойлголт

“Цэвэр агаар сан” нь иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болох бөгөөд шүүх дараах тохиолдолд иргэний хэрэг үүсгэж хэргийг шийдвэрлэнэ.

- эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэл;
- бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдээс гаргасан нэхэмжлэл;
- онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуульд заасан асуудлаар сонирхогч этгээдээс гаргасан хүсэлт;
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1, 4.2-т зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол;
- Хуульд заасан бусад үндэслэл¹¹

Дээрх нэхэмжлэлийг шүүх хүлээн авч иргэний хэрэг үүсгэнэ.

2.2.2 Иргэний нэхэмжлэл гаргах

2.2.2.1 Нэхэмжлэлийн хэлбэр

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэгч, эсхүл түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд гарын үсгээ зурсан байна.

2.2.2.2 Нэхэмжлэлийн бүрдүүлбэр

Шүүхэд гаргаж байгаа нэхэмжлэл нь доорх бүрдүүлбэрийг хангасан байх шаардлагатай.

- нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
- нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;
- нэхэмжлэлийн үнэ;
- хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

¹¹ Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн 12.1

- Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана.

Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

2.2.2.3 Нэхэмжлэлийг шүүхэд гаргах, хүлээн авах

Нэхэмжлэлийг хаана гаргах

Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд гаргана. Хэрэв хариуцагчийн оршин суугаа газар мэдэгдэхгүй байвал нэхэмжлэлийг эд хөрөнгө нь байгаа газрын шүүхэд гаргаж болдог¹².

Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч, эсхүл нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно. Гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг уг гэрээг биелүүлбэл зохих газрын шүүхэд гаргаж болно. Өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн хариуцагчид холбогдох нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн үзэмжээр хариуцагчдын аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ газрын шүүхэд гаргана.

Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

Нэхэмжлэлийг шүүх хүлээн авах

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авсаны дараа нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг хянана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг тодорхойлсон байдаг¹³.

¹² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйл

¹³ **65 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах**

65.1. Шүүгч дараах тохиолдолд захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана:

65.1.1. энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хэргийн харьяалал зөрчсөн;
/Энэ заалтыг 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

65.1.2. энэ хуулийн 14, 15, 16, 19 дүгээр зүйлд заасан шүүхийн харьяалал зөрчсөн;
/Энэ заалтыг 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

65.1.3. шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал;

65.1.4. нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байвал;

65.1.5. нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;

Ийнхүү нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байвал шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамж гаргах бөгөөд захирамждаа нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг засахыг зөвлөж зааж өгнө.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй байвал иргэний хэрэг үүсгэж мөн хэрэг үүсэх тухай захирамж гаргана.

2.2.3 Шүүх хэргийг хянан шийдвэрлэх

Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

Дээр заасан хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч болно.

Шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь:

- хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх;
- хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох ;
- хариуцагчийн дансны зарлагын хөдөлгөөнийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээнд зогсоох;
- нэхэмжлэлээр шаардсан хэмжээний мөнгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд урьдчилан оруулах;
- тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах.

зэрэг арга хэмжээ авч болох бөгөөд хэд хэдэн арга хэмжээг нэгэн зэрэг авч болдог.

Ийнхүү шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авснаар шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн

65.1.6.нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр буюу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа; /Энэ заалтад 2007 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

65.1.7.зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа;

65.1.8.уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;

65.1.9.хариуцагчийн хаяг тодорхойгүй;

65.1.10.зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;

65.1.11.энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байвал.

65.2.Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан захирамждаа уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгнө.

ажиллагаа явуулж шийдвэрийг биелүүлэхэд хялбар, түргэн шуурхай шийдвэрлэх боломжтой болдогоороо ач холбогдолтой юм.

2.2.4 Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсоны дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь зохицуулагддаг¹⁴.

2.3 Захиргааны хэрэг маргаан шийдвэрлэх

2.3.1 Захиргааны хэрэг маргааны тухай ойлголт

Дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ:

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/;
- Монгол Улсын яам;
- Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
- Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
- Монголбанк;
- Санхүүгийн зохицуулах хороо;
- яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага;
- аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
- аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/;
- улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
- аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
- төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;
- сүм хийдийн захиргаа;
- шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

¹⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

2.3.2 Гомдол, нэхэмжлэл гаргах

2.3.2.1 Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах

Хэрэв захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана.

Гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.

Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ¹⁵.

2.3.2.2 Шүүхэд нэхэмжлэл гаргах

Иргэн, хуулийн этгээд дараахь тохиолдолд холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

- Хуульд тусгайлан заасан;
- Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн;
- Захиргааны байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шийдвэрийг биелүүлээгүй;
- Шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй.
- Харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй бол иргэн, хуулийн этгээд нь зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шууд 30 хоногийн дотор захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргана¹⁶.

2.3.2.3 Нэхэмжлэлийн бүрдүүлбэр

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл түүнийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж байгаа этгээд гарын үсэг зурсан байна.

Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгана:

- Нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа;
- Нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг;

¹⁵ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 6 дугаар зүйл

¹⁶ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйл

- Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл;
- Хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, түүнчлэн нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг хавсаргана.
- Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.

Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл гэдэгт дараахь зүйл багтана:

- Захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн;
- Захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа, түүний үндэслэл;
- Захиргааны хууль бус актын улмаас ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх.

... талаар нэхэмжлэлийн шаардлагад тодорхой дурьдсан байна.

2.3.3 Шүүх хэргийг шийдвэрлэх

Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан, эсхүл нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх тухай захирамж гаргана¹⁷.

Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ¹⁸.

2.4 Бусад эрх бүхий байгууллага байгууллага албан тушаалтан

2.4.1 Захиргааны зөрчлийг шийдвэрлэх

2.4.1.1 Захиргааны зөрчлийн тухай ойлголт

Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчилд тооцдог¹⁹.

Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болдог.

- торгох;
- тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох;

¹⁷ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1

¹⁸ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1

¹⁹ Захиргааны хариуцлагын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1

- хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах;
- баривчлах²⁰.

2.4.1.2 Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээд

Дараахь албан тушаалтан энэ хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх бүрэн эрхийг эдэлнэ:

- шүүгч;
- сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
- цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан;
- хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах ;
- хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч;
- хорих ангийн дарга, жинхэнэ гүйцэтгэх ажилтан;
- консулын эрх бүхий албан тушаалтан;
- төрийн тусгай хамгаалалтын газрын гадуур хамгаалалтын алба хаагч, харуулын захирал;
- хуульд тусгайлан заасан тохиолдолд байгаль хамгаалагч;
- нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч.
- хуульд тусгайлан заасан тохиолдолд аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга²¹.

2.4.1.3 Зөрчлийг хянан шийдвэрлэх

Зөрчлийг хянан шалгах эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн зөрчлийг хянан шалгах ажиллагааг 14 хоногийн дотор явуулна.

Дээрх хугацаанд зөрчлийг хянан шалгах ажиллагааг дуусгах боломжгүй бол уг хугацааг тухайн эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр 14 хүртэл хоногоор сунгаж болно.

Зөрчлийг хянан шалгах ажиллагаанд зөрчлийн тухай тэмдэглэл хөтлөх, үзлэг шинжилгээ хийх шаардлагатай эд зүйл, баримт бичгийг түр хураах, зөрчил гаргасан этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, албадан саатуулах ажиллагаа хамаарна.

Дараах тохиолдолд зөрчлийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй:

- захиргааны хариуцлага тогтоосон хууль тогтоомж хүчингүй болсон;
- зөрчил гаргасан этгээд зөрчил үйлдэх үедээ захиргааны хариуцлага хүлээх насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүй байсан;
- зөрчил гаргасан этгээд нас барсан;
- хөөн хэлэлцэх хугацаа дууссан.

Сумын Засаг дарга баривчлах шийтгэл ногдуулах тохиолдолд зөрчлийг хянан шалгах ажиллагааг цагдаагийн эрх бүхий ажилтан гүйцэтгэнэ.

²⁰ Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1

²¹ Захиргааны хариуцлагын тухай хуулийн

Хавсралт -1

Товч хураангуй

Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд ямар хууль баримталж шийдвэрлэдэг вэ? Та ямар харилцаанд оролцож байгаа, ямар нийгмийн харилцаатай холбоотой өргөдөл гомдол гаргаж байгаагаас хамаарч тухайн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хууль нь өөр өөр байдаг. Тухайлбал эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд гаргасан хүсэлт, гомдлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль, иргэний хэрэг, маргаантай холбоотой бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны зөрчилтэй холбоотой харилцаанд Захиргааны хариуцлагын тухай, худалдаа, бизнесийн маргаантай харилцаанд оролцож байгаа бол Арбитрын тухай хуулиар шийдвэрлэдэг. Эдгээрээс бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргаж байгаа бол 1995 оны Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар тухайн харилцааг зохицуулна.

Өргөдөл гэж юу вэ? Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт болон бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг өргөдөл гэнэ. Өргөдөл нь санал, мэдэгдэл, гомдлын шинжтэй байж болно.

Санал гэж юу вэ? Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг санал гэнэ.

Мэдэгдэл гэж юу вэ? Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан хүсэлтийг мэдэгдэл гэнэ. Өөрөөр хэлбэл иргэд хамтарч мэдэгдэл гаргадаг.

Гомдол гэж юу вэ? Төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг гомдол гэнэ. Гомдлыг тухайн байгууллагын удирдах дээд шатных нь байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан байна.

Иргэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн ямар ч асуудлаар төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхтэй юу? Эрхтэй. Харин нийгмийн ямар харилцаанд оролцож байгаагаас хамаарч хандах төрийн байгууллага нь өөр өөр байна. Нөгөө талаас төрийн байгууллага, албан тушаалтан иргэдээс өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрэн хангасан байх ёстой.

Өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлэж байгаа албан тушаалтан ямар үүрэг хүлээх вэ? Өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлэж байгаа албан тушаалтан өргөдөл, гомдолд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, хугацаанд нь

үндэслэлтэй шийдвэрлэх; өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;

Өргөдөл, гомдол бичихэд хуулиар тогтоосон баримтлах зарчим байдаг уу?

Байна. Юуны өмнө өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалж болохгүй. Мөн өргөдөл, гомдол заавал үнэн зөв байх ёстой.

Өргөдөл, гомдлыг ямар хэлбэрээр гаргах вэ? Өргөдөл, гомдлыг бичгээр буюу амаар биечлэн гаргана.

Амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл, гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэнэ.

Радио, телевизийн шууд нэвтрүүлэг болон тусгайлан ажиллуулсан утсаар дамжуулан гаргасан өргөдөл, гомдлын хариуг яаж авах вэ? Энэ тохиолдолд өргөдөл, гомдолд амаар хариу өгч болох бөгөөд шаардлагатай бол шалгаж тодруулан бичгээр хариу өгч болно.

Өргөдөл, гомдол ямар шаардлага хангасан байх ёстой вэ? Бичгээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно. Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана. Өргөдөл, гомдол гаргахад энэ зүйлд зааснаас бусад зүйл шаардахыг хориглоно

Гомдлыг ямар байгууллага, албан тушаалтанд гаргах вэ? Гомдлыг түүнд холбогдож байгаа байгууллага, албан тушаалтны харьяалсан дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргана.

Хавсралт-2

ЦЭВЭР АГААР САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨГДӨХ ХУУЛЬ ТОГТООМЖ.

Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг дараах хууль, эрх зүйн актуудаар зохицуулж байна. Үүнд:

ХУУЛЬ:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Агаарын тухай
3. Агаарын бохирдлын төлбөрийн тухай
4. ЗГ-ын тусгай сангийн тухай
5. Иргэний хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн Хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
7. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай
8. Төрийн нууцын тухай
9. Хувь хүний нууцын тухай
10. Байгууллагын нууцын тухай
11. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
13. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай
14. Нягтлан бодох бүртгэлийн тухай
15. Газрын тухай
16. Төрийн албаны тухай
17. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
18. Төрийн хяналт, шалгалтын тухай
19. Төрийн аудитын тухай
20. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай
21. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай
22. Татварын ерөнхий хууль
23. Хөдөлмөрийн хууль

УИХ-ЫН ТОГТООЛ:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2011 оны 11 дүгээр тогтоол.
2. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2010 оны 36 дугаар тогтоол.
3. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого батлах тухай 1997 оны 106 дугаар тогтоол.
4. Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2007 оны 46 дугаар тогтоол.

ЗГ-ЫН ТОГТООЛ:

1. Агаарын бохирдлыг бууруулах талаар ойрын хугацаанд авах зарим арга хэмжээний тухай 2008 оны 14 дүгээр тогтоол.
2. Нийслэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2007 оны 70 дугаар тогтоол.
3. Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр батлах тухай 2005 оны 245 дугаар тогтоол.
4. Утаа багатай түлш, хэмнэлттэй зуухны үйлдвэрлэлийг дэмжих тухай 2001 оны 70 дугаар тогтоол.
5. Хөтөлбөр батлах тухай /Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр/ 1999 оны 25 дугаар тогтоол.
6. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай / Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр / 2002 оны 182 дугаар тогтоол.
7. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай /Агаарыг хамгаалах хөтөлбөр/ 1999 оны 82 дугаар тогтоол.
8. Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай 2002 оны 140 дүгээр тогтоол.
9. Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох журам. 1999 оны 104 дүгээр тогтоол.
10. Хөтөлбөр батлах тухай /Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр 1999 оны 50 дугаар тогтоол.
11. Үндэсний хөтөлбөр батлах тухай /Озоны үе давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөр 1999 оны 129 дүгээр тогтоол.
12. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах, олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журам. 2010 оны 273 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.
13. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам. 2011 оны тогтоолын 1 дүгээр хавсралт.
14. Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам. 2011 оны дугаар тогтоолын 2 дугаар хавсралт.

БОАЖ-ЫН САЙДЫН ТУШААЛ

1. Журам батлах тухай / Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны дүрэм, Агаарын чанарын мэдээлэл гаргах журам, Иргэн,аж ахуйн нэгж,байгууллагын суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээ тогтоох төсөл боловсруулах журам, Агаарыг бохирдуулах эх үүсвэрийн улсын тоо бүртгэл явуулах журам, Иргэн,аж ахуйн нэгж,байгууллагын суурин эх үүсвэрээс агаарт бохирдуулах бодис гаргах зөвшөөрөл олгох журам/ 1996 он. Дугаар 98
2. Заавар батлах тухай /Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөх аргачилсан заавар, Химийн бодисын улсын үзлэг, тооллого явуулах аргачилсан заавар/ 2000 он. Дугаар 45
3. Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам. 2011. А-200 тоот тушаал. 4 дүгээр хавсралт
4. Цэвэр агаарын сангийн дүрэм. 2011 оны А-200 тоот тушаал. 1 дүгээр хавсралт.
5. Цэвэр агаарын сангийн стратеги, бүтэц зохион байгуулалтын хөтөлбөр. 2011 оны А-200 тоот тушаал. 2 дугаар хавсралт.
6. Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааны төсөв, урсгал зардал. 2011 оны А-200 тоот тушаал. 3 дугаар хавсралт.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1. Жагсаалт, журам батлах тухай /Химийн бодисын хаягдлыг байгаль орчинд халгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах технологийн аргачилсан заавар , Аюултай, хортой химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, тээвэрлэх, ашиглах, үйл ажиллагааг зохицуулах журам /2003 он. Дугаар 126/171

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх журам. 2011 оны 131 дүгээр тогтоол. 1 дүгээр хавсралт.
2. Боловсруулсан түлш нөөцлөх, дүүрэг, хороо, иргэдэд хүргэх журам. 2011 оны 131 дүгээр тогтоол. 2 дугаар хавсралт.
3. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд хяналт тавьж ажиллах орон тооны бус байцаагчийн ажиллах журам. 2011 оны 131 дүгээр тогтоол. 3 дугаар хавсралт.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1. Хязгаарлалтын бүс тогтоохтой холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай. 2011 оны 351 тоот захирамж.

ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2. Хөдөлмөрийн дотоод журам. 2011 оны 7 дугаар тушаал.